



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/134

Хэрлэн сум


**Нийтийн тээврийн хэрэгслээр
үнэ төлбөргүй зорчсоны нөхөн олговорт
хөрөнгө зарцуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Ахмад настны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.8 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны хорин гуравдугаар хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийтийн тээврийн газраас ирүүлсэн нэхэмжлэхийн дагуу аймгийн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 2023 оны 4 дүгээр улирал болон 2024 онд нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчсоны нөхөн олговорт 19,620,000 (арван есөн сая зургаан зуун хорин мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг “Засаг дарга данс” зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийн түр орлон гүйцэтгэгч (Н.Зоригтбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ